



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/377

Мөрөн сум

Газар эзэмших эрхийг дуусгавар  
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 39 дүгээр зүйлийн 39.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2011 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/290 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 6 дахь заалтаар газар эзэмшигч ерөнхий боловсролын “Нутгийн аваргууд” /4125495/ сургуулийн Мөрөн сум 8 дугаар багт байршилтай 6072.7м<sup>2</sup> сургалтын зориулалттай эзэмшил газрынхаа газар эзэмших гэрчилгээ, гэрээгээ цуцлах хүсэлт гаргасны дагуу газар эзэмших эрхийг нь дуусгавар болгож нийтийн эзэмшилд шилжүүлсүгэй.


2. Уг захирамжаар газар эзэмшиж байсан ерөнхий боловсролын “Нутгийн аваргууд” /4125495/ сургуулийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож газар эзэмшигчийн мэдээллийн сангаас хасалт хийхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр)-т тус тус даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН